MONGOLIAN STOCK EXCHANGE

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2026 оны 10 сарын 26 өдөр Дугаар 46 Улаанбаатар хот

Гүйцэтгэх захиралтай хөдөлмөрийн гэрээ байгуулах, цалин хөлсийг тогтоохтой холбогдуулан авах арга хэмжээний тухай

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.9, 76.1.18 дахь заалт, "Монголын хөрөнгийн бирж" ХК-ийн Дүрмийн 5 дугаар зүйлийн 5.7.9 дахь заалт, "Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журам"-ын 2 дугаар зүйлийн 2.5.4, 2.8.1 дэх заалт, "Журам батлах тухай" Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2022 оны 05 дугаар сарын 03-ны өдрийн 184 дүгээр тогтоолын 3 дахь заалт, Үндэсний аудитын газрын 2026 оны 03 дугаар сарын 16-ны өдрийн 699/А0150061 дугаар албан шаардлага, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн хурлын дэлгэрэнгүй тэмдэглэлийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. "Монголын хөрөнгийн бирж" ХК-ийн гүйцэтгэх захирал болон гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгчтэй байгуулах онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээний нөхцөл, загварыг "Журам батлах тухай" Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2022 оны 05 дугаар сарын 03-ны өдрийн 184 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтаар батлагдсан Төрийн өмчийн хувьцаат компанийн гүйцэтгэх захиралтай байгуулах онцгой нөхцөл бүхий гэрээний загвар"-ын дагуу хавсралт ёсоор баталсугай.

2. "Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээ" байгуулах, дүгнэх, урамшуулал олгох болон түүний цалин хөлсийг тогтоохтой холбоотой харилцаанд Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2022 оны 05 дугаар сарын 03-ны өдрийн 184 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан "Төрийн өмчит хуулийн этгээдийн захиралтай онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээ байгуулах, дүгнэх журам", түүний хавсралтуудаар батлагдсан аргачлалыг тус тус мөрдсүгэй.

3. Үндэсний аудитын газрын 2026 оны 03 дугаар сарын 16-ны өдрийн гаргасан 699/А0150061 дугаар албан шаардлагын хэрэгжилтийг хангах чиглэлээр холбогдох арга хэмжээ авч ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн Нарийн бичгийн дарга Ж.Золбаярт үүрэг болгосугай.

1526010135

4. Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Аудитын хороо (Ж.Золзаяа)-нд даалгасугай.



ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА Ш.БАТ-ЭРДЭНЭ

Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны 10 дугаар
сарын 26-ны өдрийн 46 дугаар тогтоолын хавсралт

“МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ ЭСВЭЛ ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ БОЛОН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХООРОНДЫН ОНЦГОЙ НӨХЦӨЛ БҮХИЙ ХӨДӨЛМӨРИЙН ГЭРЭЭНИЙ ЗАГВАР

2026 оны ....-р сарын ....-ны өдөр № Улаанбаатар хот

Энэхүү гэрээг нэг талаас "Монголын хөрөнгийн бирж” ХК (цаашид “Компани” гэх) -ийн Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид “ТУЗ” гэх), түүнийг төлөөлж ТУЗ-ийн дарга ..... овогтой .....,

Нөгөө талаас “Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн Гүйцэтгэх захирал эсвэл Гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч ..... овогтой ...../РД:...../ (цаашид “Гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч” гэх), (цаашид хамтад нь “Талууд” гэх) нар компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 20... оны .... -р сарын ....-ны өдрийн ...-р тогтоол болон Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хуулийн 65 дугаар зүйлийг үндэслэн харилцан тохиролцож, дор дурдсан нөхцөлөөр байгуулав.

Нэг.Ерөнхий зүйл

1.1. Энэхүү гэрээний зорилго нь Гүйцэтгэх захирал эсвэл Гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч Компанийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулах, өмч хөрөнгийг хууль тогтоомжийн дагуу зүй зохистой захиран зарцуулах, хөрөнгийг үр ашигтай эзэмшин ашиглаж, Компанийн үйл ажиллагаа, үйлчилгээ, үр ашгийг дээшлүүлэх, хууль тогтоомж, гэрээгээр хүлээсэн эрх, үүргээ хэрэгжүүлэхтэй холбогдон үүсэх харилцааг зохицуулж, хариуцлагыг тодорхойлохтой холбоотой харилцааг зохицуулахад оршино.

1.2. Гүйцэтгэх захирал эсвэл Гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч үйл ажиллагаандаа “Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль”, “Компанийн тухай хууль”, “Үнэт цаасны зах зээлийн тухай хууль”, “Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хууль” болон бусад холбогдох хууль тогтоомж, эрх бүхий байгууллагын дүрэм, журам, Компанийн дүрэм, журам, энэхүү гэрээ, Төрийн эрх бүхий байгууллага, Компанийн ТУЗ-ийн шийдвэрийг удирдлага болгон ажиллана.

1.3. Талууд гэрээгээр хүлээсэн үүргээ шударгаар, зохих ёсоор биелүүлэх бөгөөд гэрээнд тусгагдаагүй талуудын хооронд үүссэн бусад харилцааг Иргэний хууль болон бусад холбогдох хууль тогтоомж, дүрэм, журамд заасны дагуу зохицуулна.

1.4. Гүйцэтгэх захирал эсвэл Гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч гуравдагч этгээдээр ажлаа гүйцэтгүүлэхгүй, өөр аж ахуйн нэгжид давхар ажил, албан тушаал эрхлэхгүй бөгөөд зөвхөн энэ гэрээгээр тохиролцсон үүрэг, хариуцлагыг ТУЗ-ийн өмнө биечлэн хариуцна.

Хоёр.Төлөөлөн удирдах зөвлөлийн эрх, үүрэг

2.1. ТУЗ дараах эрхийг эдэлнэ. Үүнд:

2.1.1. Гүйцэтгэх захирал эсвэл Гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгчийн үйл ажиллагаатай танилцах, шалгах, зөвлөх, шаардлага

тавих;

2.1.2. Гүйцэтгэх захирал эсвэл Гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч Компанийн үйл ажиллагаанд их хэмжээний хохирол (Эрүүгийн хуульд тодорхойлсноор ойлгоно) учруулсан тохиолдолд гэрээг нэг талын санаачилгаар цуцлах;

2.1.3. Компанийн жилийн эцсийн санхүүгийн тайлан тэнцэл, түүнд хийсэн аудитын дүгнэлт, гэрээний үүргийн биелэлтийг хэлэлцэн үнэлэлт, дүгнэлт өгөх;

2.1.4. Компанийн тайлан тэнцэл, мэдээ судалгаанд үндэслэн тэдгээрийн менежментийн байдал, үйлдвэрлэл, технологи, эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүд, бизнес төлөвлөгөөний гүйцэтгэлд улирал, хагас, бүтэн жилээр судалгаа, шинжилгээ хийж, үнэлэлт дүгнэлт өгч, авах;

2.1.5. Компанийн удирдлага, аж ахуй, санхүүгийн үйл ажиллагаанд ТУЗ-ийн дэргэдэх хороо, аудитораар дамжуулан болон холбогдох этгээдтэй хамтарсан хяналт шалгалт хийх;

2.1.6. хууль, журамд заасан бусад.

2.2. ТУЗ дараах үүргийг хүлээнэ. Үүнд:

2.2.1. Компанийн нийт хөрөнгийг /балансад тусгагдсаны дагуу/, Гүйцэтгэх захирал эсвэл Гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгчид зохих журмын дагуу хүлээлгэж өгөх;

2.2.2. Гүйцэтгэх захирал эсвэл Гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгчид цалин хөлс, бусад урамшууллыг олгох;

2.2.3. Гүйцэтгэх захирал эсвэл Гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгчийг холбогдох хууль тогтоомж болон энэхүү гэрээг зөрчсөн гэж үзвэл энэхүү гэрээг цуцлах;

2.2.4. хуульд заасан бусад.

Гурав. Гүйцэтгэх захирал эсвэл Гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгчийн эрх, үүрэг

3.1. Гүйцэтгэх захирал эсвэл Гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч дараах эрхийг эдэлнэ. Үүнд:

3.1.1. Компанийн хөрөнгийг ТУЗ-өөс олгосон эрх хэмжээний дотор захиран зарцуулах;

3.1.2. шаардлагатай гэж үзвэл ТУЗ-ийн ээлжит бус хурал хуралдуулах саналыг гаргах;

3.1.3. ТУЗ-өөс олгосон эрх, хэмжээний хүрээнд Компанийг төлөөлж, шүүхэд нэхэмжлэл гаргаж, хариуцагч, гуравдагч этгээдээр оролцох;

3.1.4. бүрэн эрхэд хамаарах асуудлаар хууль тогтоомжид нийцүүлэн Компанийн хэмжээнд дагаж мөрдөх тушаал гаргаж, журам, заавар батлах;

3.1.5. Компанийн ажиллагсдын нийгмийн асуудлыг шийдвэрлэхтэй холбогдуулан батлагдсан төсвийн хүрээнд хөрөнгө оруулалт хийх;

3.1.6. хууль, дүрэм, журамд заасан бусад.

3.2. Гүйцэтгэх захирал эсвэл Гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч дараах үүргийг хүлээнэ. Үүнд:

3.2.1. Компанийн тухайн жилийн үйл ажиллагааны зорилтот түвшин, ТУЗ-ийн баталсан бизнес төлөвлөгөөг хэрэгжүүлэх, Компанийн ашиг, орлогыг нэмэгдүүлэх;

3.2.2. биржийн үнэт цаасны арилжааг хангах, санхүүгийн тогтвортой байдлыг хангах, техник технологийг сайжруулах, бүтээгдэхүүний нэр төрлийг нэмэгдүүлэх, хөдөлмөрийн бүтээмжийг дээшлүүлэн, өртөг, зардлыг

хямдруулах, бүтээгдэхүүний чанарыг сайжруулах зохион байгуулалтын арга хэмжээ авч хэрэгжүүлэх;

3.2.3. үнэт цаас зах зээлийг хөгжүүлэх талаарх Засгийн газрын үйл ажиллагааны бодлого, хөтөлбөртэй уялдуулан Компанийн үйл ажиллагааны стратеги төлөвлөгөө, бизнес төлөвлөгөөг сайжруулах чиглэлээр санал, төсөл боловсруулж, ТУЗ-д танилцуулан хэлэлцүүлэх;

3.2.4. гэрээний биелэлтийн тухай тайланг Компанийн жилийн эцсийн тайлан тэнцлийн хамт ТУЗ-д танилцуулан хэлэлцүүлж, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт дараа оны 03 дугаар сарын 01-ний дотор хүргүүлэх;

3.2.5. ТУЗ-өөс өгсөн үүрэг, даалгаврыг тухай бүр биелүүлэх;

3.2.6. Компанийн хэмжээнд хууль тогтоомж, дүрэм журмын хэрэгжилтийг хангуулах;

3.2.7. хууль, дүрэм, журамд заасан бусад.

3.3. Гүйцэтгэх захирал эсвэл Гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч дараах асуудлыг ТУЗ-ийн зөвшөөрлийг авсны үндсэн дээр шийдвэрлэнэ. Үүнд:

3.3.1. Компанийн эрхлэх үндсэн үйл ажиллагааны төрөл, чиглэлээс өөр үйлдвэрлэл, үйлчилгээ явуулах;

3.3.2. Компанийн үл хөдлөх болон үндсэн хөрөнгөд бүртгэлтэй хөрөнгийг данснаас хасах, захиалах, шинээр авах;

3.3.3. бусад хуулийн этгээдтэй хамтран хуулийн этгээд байгуулах, хөрөнгө оруулах, оруулсан хувь хөрөнгөө татан авах;

3.3.4. бусад этгээдэд Компанийн барилга, байгууламжийг түрээслүүлэх;

3.3.5. түрээслүүлсэн барилга, байгууламжид хөрөнгө оруулалт хийх зөвшөөрөл олгох;

3.3.6. Компанийн бизнесийн үйл ажиллагаатай холбоотой зардлын төсөв батлах;

3.3.7. сонирхлын зөрчилтэй гэрээ, хэлцэл хийх;

3.3.8. их хэмжээний хэлцэл хийх, эд хөрөнгийн болон эд хөрөнгийн эрхийн зах зээлийн үнийг тогтоох;

3.3.9. Компанийн бизнес төлөвлөгөөнд тусгагдаагүй, хэрэгцээнээс илүү хэмжээний үндсэн ба туслах материал, үндсэн үйлдвэрлэлтэй холбогдолгүй бараа, техник хэрэгсэл худалдан авахтай холбогдуулан гадаад дотоодын иргэн, аж ахуйн нэгж, байгууллагатай гэрээ хэлцэл хийх;

3.3.10. банк, санхүүгийн байгууллагаас зээл авах.

3.3.11. хууль, дүрэм, журамд заасан бусад.

3.4. Гүйцэтгэх захирал эсвэл Гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч ТУЗ-ийн зөвшөөрөлгүйгээр Компанийн хөрөнгөөс зээл олгох, хандивлах, бэлэглэх, бусдад хөрөнгийн баталгаа гаргах, бусад аливаа хэлбэрээр гуравдагч этгээдийн өмнө санхүүгийн үүрэг хүлээхийг хориглоно.

3.5. Гүйцэтгэх захирал эсвэл Гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч нь тогтсон журмын дагуу хувь нийлүүлэгчид олгох ногдол ашгийн тооцооны саналыг ТУЗ-ийн хуралд танилцуулан шийдвэр гаргуулна.

3.6. Компанийн үйлдвэрлэл, технологи, бизнесийн нууцад хамаарах мэдээллийн зэрэглэлийг холбогдох хууль тогтоомжийн дагуу тогтоож, түүнийг хадгалах, хамгаалах, задруулахгүй байхтай холбогдох арга хэмжээ авна.

3.7. Гүйцэтгэх захирал эсвэл Гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч нь Компанийн эд хөрөнгийн эзэмшилт, ашиглалт, захиран зарцуулалт, хамгаалалтын байдалд өдөр тутам тавих дотоод хяналтыг удирдан зохион байгуулж, өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, ашиглалтын асуудлыг ТУЗ-ийн өмнө хариуцна.

3.8. Компанийн эд хөрөнгийн тооллогыг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуульд заасан журмын дагуу хийж хагас, бүтэн жилийн тайлан тэнцэлд тусгаж баталгаажуулна.
3.9. Компанийн санхүүгийн тайлан тэнцлийг хуульд заасан журмын дагуу гаргах ажлыг зохион байгуулж ТУЗ-д танилцуулж, хагас бүтэн жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нэг хувийг холбогдох журмын дагуу Сангийн яаманд хүргүүлнэ.
3.10. Гүйцэтгэх захирал эсвэл Гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч ТУЗ-өөс өгсөн үүрэг даалгавар зөвлөмжийг заасан хугацаанд нь хэрэгжүүлж, биелэлтийн талаар тухай бүр бичгээр мэдэгдэнэ.
3.11. Гүйцэтгэх захирал эсвэл Гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч нь энэхүү гэрээний 3.10-д заасан мэдээллийг өгөөгүй буюу тухай бүр мэдэгдээгүйгээс компанид болон хувьцаа эзэмшигчид хохирол учруулсан бол уг хохирлыг Гүйцэтгэх захирал эсвэл Гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч нөхөн төлнө.
3.12. Гүйцэтгэх захирал эсвэл Гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, зохион байгуулахдаа Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, түүнд нийцүүлэн гаргасан журам, зааврыг дагаж мөрдөнө.

Дөрөв.Цалин хөлс, урамшуулал, ажлын нөхцөл

4.1. Гүйцэтгэх захирал эсвэл Гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгчид сард .....(.....) төгрөгийн үндсэн цалинг олгоно.
4.2. Гүйцэтгэх захирал эсвэл Гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгчийн ажлыг тайлант жилээр тасалбар болгон ТУЗ-өөс дүгнэнэ.
4.3. Гүйцэтгэх захирал эсвэл Гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгчийн "Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээ"-г дүгнэх үед тайлант жилийн ажлын үр дүн, компанийн ашигт ажиллагааны үзүүлэлт зэргийг харгалзан сарын цалин хөлсийг шинэчлэн тогтоож болно.
4.4. Гүйцэтгэх захирал эсвэл Гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгчид Компанийн үйл ажиллагааны эдийн засаг, санхүүгийн үр ашиг, эд хөрөнгийн эзэмшилт, ашиглалт, хадгалалт, хамгаалалт, хууль тогтоомжийн хэрэгжилт, дараа оны ажлын бэлтгэл зэргийг харгалзан урамшуулал олгох эсэхийг ТУЗ шийдвэрлэнэ.
4.5. Гүйцэтгэх захирал эсвэл Гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгчид холбогдох хууль тогтоомжийн дагуу ээлжийн амралт олгоно.
4.6. Гүйцэтгэх захирал эсвэл Гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгчийн албан үүргээ биелүүлэхэд шаардагдах ажлын байр, шаардагдах техник хэрэгсэл, үүрэн телефоноор хангана. Үүрэн телефон хэрэглэх зардлыг тогтоохдоо Засгийн газар, Сангийн яамны тогтоосон лимитийг баримтална.

Тав.Хариуцлага

5.1. Талууд гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй бол холбогдох хууль тогтоомж, Компанийн дүрэм, гэрээнд заасан хариуцлага хүлээнэ.
5.2. Гүйцэтгэх захирал эсвэл Гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч холбогдох хууль, Компанийн дүрэм, журам, энэхүү гэрээгээр ТУЗ-өөс олгосон хөрөнгөө захиран зарцуулж, эрхээ хэтрүүлэх буюу урвуулан ашиглах зэргээр Компани, хувьцаа эзэмшигчид хохирол учруулсан бол зохих журмын дагуу хууль хяналтын байгууллагад хандан шийдвэрлүүлнэ.

5.3. Гүйцэтгэх захирал эсвэл Гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч гэм буруутай үйл ажиллагаанаас болж гэрээнд заасан эд хөрөнгө эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхээ хэтрүүлэн, урвуулан ашиглах зэргээр компанид хохирол учруулсан бол уг хохирлыг гүйцэтгэх захирал эсвэл гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч өөрийн хувийн өмчийн эд хөрөнгөөр бүрэн хариуцна.

Зургаа. Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах, гэрээг цуцлах

6.1. Талууд харилцан тохиролцон хэдийд ч гэрээг цуцлах ба гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулж болно. Гэрээний нэмэлт, өөрчлөлтийг бичгээр хийх ба талууд гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болно.Гэрээ нь дор дурдсан үндэслэлээр дуусгавар болно. Үүнд:
6.1.1. гэрээний хугацаа дууссан;
6.1.2. ТУЗ-өөс гэрээг цуцлах шийдвэр гаргасан;
6.1.3. Гүйцэтгэх захирал эсвэл гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгчийн өөрийн хүсэлтээр.
6.2. Гүйцэтгэх захирал эсвэл Гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгчийн санаачилгаар дараах тохиолдолд гэрээг хугацаанаас нь өмнө цуцална. Үүнд:
6.2.1. өвчний улмаас компанийг удирдах чадваргүй болсон;
6.2.2. өөрийн хүсэлтээр;
6.2.3. бусад хүндэтгэх шалтгаан бий болсон.
6.3. ТУЗ дараах тохиолдолд гэрээг хугацаанаас нь өмнө цуцлах эрхтэй. Үүнд:
6.3.1. Гүйцэтгэх захирал эсвэл Гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч хууль тогтоомж, холбогдох дүрэм журам, компанийн дотоод хэм хэмжээ, энэхүү гэрээг удаа дараа зөрчсөн, тус эрх зүйн актуудаар хүлээсэн үүргээ биелүүлээгүй;
6.3.2. Гүйцэтгэх захирал эсвэл Гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч хууль тогтоомж, дүрэм журам, энэхүү гэрээнд заагдсан үүргээ биелүүлээгүй, зөрчсөнөөс Компани, хувьцаа эзэмшигчдэд хохирол учруулсан;
6.3.3. Гүйцэтгэх захирал эсвэл Гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч Компанийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулах үүргээ удаа дараа зөрчсөн;
6.3.4. ТУЗ-ийн шийдвэрийг хүндэтгэх шалтгаангүйгээр биелүүлээгүй;
6.3.5. Гүйцэтгэх захирал эсвэл Гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч нь эрх, үүргээ хэрэгжүүлэх чадваргүй болсон;
6.3.6. Компани татан буугдсан, Компанийн төрийн мэдлийн хувьцаа бусад этгээдийн өмчлөлд шилжсэн;
6.3.7. гэмт хэрэг үйлдсэн болох нь шүүхийн шийдвэрээр тогтоогдсон;
6.3.8. Төлөөлөн удирдах зөвлөлөөс өөр этгээдийг Гүйцэтгэх захирлаар томилох шийдвэр гаргасан;
6.3.9. ТУЗ-ийн итгэлийг алдсан буруутай үйлдэл, эс үйлдэхүй гаргасан нь хууль хяналтын, аудитын зэрэг эрх бүхий байгууллагын шалгалт, мөн дотоодын хяналт шалгалтаар тогтоогдсон;
6.3.10. хуульд болон энэхүү гэрээнд заасан бусад үндэслэлүүд.
6.4. Энэхүү гэрээ дуусгавар болсон, хугацаанаас нь өмнө цуцалсан тохиолдолд ТУЗ өмч хөрөнгийн эзэмшилт, ашиглалтыг тогтоон Компанийн хөрөнгийн тооллого явуулан бүртгэж, дараагийн Гүйцэтгэх захирал эсвэл Гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч ажил хүлээлцүүлнэ.
6.5. Гүйцэтгэх ажлын төрөл, хэмжээ, хөлс болон бусад гол нөхцөлд өөрчлөлт оруулах тохиолдолд өөрчлөлтийг нэмэлт гэрээгээр баталгаажуулах эсхүл аль

тохирох төрлийн гэрээг шинээр байгуулж болно.

Долоо. Гэрээний хугацаа

7.1. Энэхүү гэрээ нь "Гүйцэтгэх захирал эсвэл Гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгчийг томилох тухай ТУЗ-ийн 20.... оны ....-р сарын ....-ны өдрийн ....-р тогтоол" гарсан өдрөөс эхлэн *"1 /нэг/ жилийн хугацаанд хүчинтэй байна./Компанийн гүйцэтгэх захирлыг нээлттэй сонгон шалгаруулалтаар сонгож, томилох хүртэл хугацаатай байна."*

7.2. Энэ гэрээний 7.1-т заасан хугацаанаас өмнө ТУЗ нь Компанийн тухай хуулийн 83 дугаар зүйлийн 83.15 дахь хэсгийн дагуу хэдийд ч гэрээг дуусгавар болгох эрхтэй байна.

7.2. ТУЗ нь энэхүү гэрээний хэрэгжилтийг шаардлагатай гэж үзвэл тухай бүр дүгнэнэ.

Найм. Бусад

8.1. Энэ гэрээнд Талууд тохиролцсоны дагуу оруулсан нэмэлт, өөрчлөлт нь үндсэн гэрээний салшгүй нэг хэсэг байна.

8.2. Гэрээний Талуудын хооронд үүссэн маргааныг Монгол Улсын хуулийн дагуу Монгол Улсын шүүхээр шийдвэрлүүлнэ.

8.3. Энэхүү гэрээг 2 эх хувь үйлдэн талууд хадгалах ба гэрээний Талууд гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болно.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА:	ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ ЭСВЭЛ ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ:
..... /...../	..... /...../